УДИРДЛАГЫН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

ISO 9001:2015, ISO 21001:2018

2026 оны 10 дугаар сарын 30-ны өдөр

МУИС-ийн нэгдсэн менежментийн тогтолцооны удирдлагын дүн шинжилгээний хурал 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 10:00 цагт БОХТ-ийн 506 тоот өрөөнд болов.

Хуралд оролцсон:

МУИС-ийн ректор Б.Очирхуяг, Инженер, технологийн сургуулийн захирал Ч.Сономдагва, Улс төр судлал, олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийн захирал С.Мөнхбат, Шинжлэх ухааны сургуулийн Байгалийн ухааны салбарын захирал Г.Мөнхбаяр, Бизнесийн сургуулийн Санхүү, бүртгэлийн салбарын дэд захирал М.Эрдэнэбат, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга П.Лхамсүрэн, Цахим шилжилтийн газрын дарга А.Баатарбилэг, Сургалт, хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын газрын дарга С.Булгантамир, Судалгаа, хөгжүүлэлтийн газрын дарга Н.Эрдэнэ, Хамтын ажиллагааны газрын дарга Ш.Мэндбаяр болон дотоод аудиторууд, ажлын хэсгийн гишүүд оролцов.

НЭГ. ХУРЛЫН ЗОРИЛГО

ISO 9001:2015, ISO 21001:2018 стандартын хүрээнд хэрэгжүүлж буй нэгдсэн менежментийн тогтолцооны гүйцэтгэл, үр нөлөөнд дүн шинжилгээ хийж, дотоод аудитын үр дүн, сонирхогч талуудын сэтгэл ханамж, эрсдэл ба боломж, нөөцийн хүрэлцээ болон сайжруулалтын хэрэгцээг хэлэлцэн, удирдлагын түвшинд хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлийг тодорхойлоход оршино.

ХОЁР. ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ

1. Нэгдсэн менежментийн тогтолцооны хэрэгжилт, бодлого, зорилтын биелэлт, үйл явцын гүйцэтгэл, өмнөх хурлын шийдвэрийн хэрэгжилт;
2. Дотоод аудитын үр дүн, үл тохирол, залруулах болон сайжруулах арга хэмжээ;
3. Сонирхогч талуудын сэтгэл ханамж, эрсдэл ба боломж, нөөцийн хүрэлцээ;
4. Удирдлагын хэлэлцүүлэг, сайжруулалтын хэрэгцээ, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ.

ГУРАВ. ТАНИЛЦУУЛГА, МЭДЭЭЛЭЛ

Б.Ганбат: МУИС нь 2025 оны 12 дугаар сард захиргааны төвлөрсөн нэгжүүд болон зургаан бүрэлдэхүүн сургуулийн хүрээнд ISO 9001, ISO 21001 стандартын баталгаажуулалтад хамрагдсан талаар мэдээлэв.

Нэгдсэн менежментийн тогтолцооны хэрэгжилтэд хийх магадлах аудит 2026 оны 11 дүгээр сарын 4–6-ны өдрүүдэд зохион байгуулагдахтай холбогдуулан ректорын тушаалаар ажлын хэсэг байгуулж, баримт бичгийн бүрдэл, шинэчлэл, сайжруулалт болон дотоод аудитын ажлыг зохион байгуулсныг танилцуулав.

Мөн стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн талаарх хэлэлцэгдэж буй хуулийн төслийн зарим зохицуулалтын талаар мэдээлэл өгч, менежментийн тогтолцооны хэрэгжилтэд удирдлагын манлайлал, нотолгоонд суурилсан үнэлгээ, эргэх холбоо, ил тод байдал чухал болохыг онцлов.

Дотоод аудитыг Захиргаа, төвлөрсөн сангийн таван газар, зургаан бүрэлдэхүүн сургууль болон Шинжлэх ухаан, технологийн Улаанбаатар паркийг хамруулан нийт 12 нэгжид зохион байгуулсан бөгөөд дараах үр дүн гарсныг танилцуулав.

Үзүүлэлт	Тоо
Тохирол	341
Үл тохирол	0
Анхаарах асуудал	33
Сайжруулах боломж	28
Давуу тал	5

Аудитын явцад үл тохирол бүртгэгдээгүй боловч зарим сургууль, нэгжийн эрсдэлийн шинжилгээ, баримтжуулалт, шийдвэрийн хэрэгжилт, хяналт болон сайжруулалтын үйл ажиллагааг боловсронгуй болгох шаардлага байгааг тэмдэглэв.

2025 оны хөндлөнгийн аудитын үр дүнгээр үл тохирол 0, сайжруулах боломж 5, анхаарах асуудал 6, давуу тал 4 бүртгэгдэж, нэгдмэл байдлын үнэлгээ 82 хувьтай гарсныг танилцуулав.

Өмнөх аудитын зөвлөмжийн мөрөөр эрүүл мэндийн үйлчилгээний гэрээ байгуулах, сэтгэл зүйн үйлчилгээний чиг үүргийг ажлын байрны тодорхойлолттой уялдуулах зэрэг арга хэмжээ авсныг мэдээлэв.

Мөн нэгдсэн менежментийн тогтолцооны гарын авлага, хамрах хүрээ, холбогдох журам, үйл явцын зураглалыг шинэчлэх, цахим хуудсан дахь мэдээллийг сайжруулах, сургалтын хөтөлбөрийн үнэлгээ болон мэдээллийн технологийн холбогдох нотолгоонд шинжилгээ хийх ажлууд хэрэгжиж байгааг танилцуулав.

Удирдлагын түвшинд эрсдэл ба боломжийн удирдлага, баримтжуулалт, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, сургалтын орчны хүртээмж, судалгааны үр дүнд үндэслэсэн шийдвэр болон эргэх холбоог сайжруулах шаардлагатай байгааг онцлов.

ДӨРӨВ. ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, САНАЛ

Б.Очирхуяг: Багш, ажилтны сэтгэл ханамжийн судалгааны явц, хамрагдсан хүний тоо, судалгааны үр дүнг нэгтгэсэн эсэхийг тодруулав.

Б.Ганбат: Багшийн сэтгэл ханамжийн судалгаанд 166, ажилтны судалгаанд 42 хүн хамрагдсан бөгөөд үр дүнг нэгтгэх ажил үргэлжилж байгааг мэдээлэв. Багшийн судалгаа нээлттэй, ажилтны судалгаа хаагдсан болохыг тайлбарлав. Өмнөх жилийн судалгаатай харьцуулах зорилгоор асуулгын үндсэн бүтцийг өөрчлөөгүйг дурдав.

Б.Очирхуяг: Ажилтны судалгаанд хамрагдсан хүний тоо харьцангуй бага байгааг анхааруулж, судалгааны үр дүнг өмнөх онтой харьцуулан дүн шинжилгээ хийх шаардлагатайг тэмдэглэв.

Мөн МУИС-ийн хэмжээнд эрсдэлийн үнэлгээ хийх нэгдсэн аргачлал, эрсдэлийн ангилал, үнэлгээний үр дүнгийн талаар тодруулав.

Б.Ганбат: Нэгдсэн менежментийн тогтолцооны ажлын хэсгийн хүрээнд эрсдэл, боломжийн бүртгэл болон хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалт боловсруулсныг

мэдээлэв. Бүрэлдэхүүн сургууль, нэгж бүр өөрийн үйл ажиллагааны эрсдэл, боломжийг тодорхойлж, нэгдсэн мэдээлэл бүрдүүлэх шаардлагатай байгааг тайлбарлав.

Эрсдэлийн үнэлгээ хийх загвар, аргачлалын материалыг сургуулиудад хүргүүлсэн бөгөөд тухайн үеийн байдлаар Мэдээллийн технологи, электроникийн сургууль болон Инженер, технологийн сургуулиас мэдээлэл ирүүлснийг дурдав.

Ч.Сономдагва: Дотоод аудитын явцад сургуулийн барилга байгууламжийн аюулгүй байдал, галын гарц, хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой асуудлуудыг сургуулийн удирдлага дангаар хариуцах мэтээр тусгаж байгааг анхааруулав. Эдгээр чиг үүргийг хэрэгжүүлэхэд захиргааны холбогдох мэргэжлийн нэгж, ажилтнуудын үүрэг, оролцоо, хариуцлагыг тодорхой болгох шаардлагатай талаар санал гаргав.

Б.Ганбат: Менежментийн тогтолцооны хэрэгжилт нь зөвхөн нэг ажилтан, нэгжийн үүрэг бус, байгууллагын бүх түвшний оролцоонд тулгуурлах ёстойг тайлбарлав.

Б.Очирхуяг: Аюулгүй байдлын үнэлгээ, холбогдох арга хэмжээг сургуулийн захирал санаачлан, чиг үүргийн дагуу хариуцсан мэргэжлийн ажилтнуудтай хамтран хэрэгжүүлэх шаардлагатайг тэмдэглэв. Мөн дотоод аудитын явцад барилга байгууламжийн нөхцөл байдлыг газар дээр нь үзэж үнэлсэн эсэхийг тодруулав.

Б.Ганбат: Аудиторууд хуваарийн дагуу холбогдох байршилд ажиллаж, нөхцөл байдлыг газар дээр нь үзэж танилцсаныг мэдээлэв.

М.Эрдэнэбат: Бизнесийн сургуулийн аудитын тайланд дурдсан сэтгэл ханамжийн судалгаа нь багш, ажилтан, оюутан, төгсөгчдийн аль судалгаанд хамаарч байгааг тодруулж, судалгааны мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээг хэрхэн нотлох талаар асуув.

Б.Ганбат: Танилцуулгад багш, ажилтны сэтгэл ханамжийн судалгааг тусгасан бөгөөд оюутны сэтгэл ханамжийн судалгааг холбогдох нэгжүүд зохион байгуулж байгааг тайлбарлав.

Б.Болормаа: Бизнесийн сургуулийн аудитын хүрээнд багш, оюутны сэтгэл ханамжийн судалгаа болон түүний мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээг авч үзсэн бөгөөд холбогдох нотолгоог баримтжуулах шаардлагатайг тайлбарлав.

Н.Эрдэнэ: Судалгаа, хөгжүүлэлтийн газрын аудитын тайланд дурдсан байгууллагын орчны болон эрсдэлийн шинжилгээ дутуу гэсэн анхаарах асуудлын агуулгыг тодруулав.

Б.Ганбат: Байгууллагын орчны шинжилгээ нь тухайн нэгжийн үйл ажиллагаанд нөлөөлөх дотоод, гадаад нөхцөл байдлыг тодорхойлох бөгөөд уг шинжилгээнд тулгуурлан эрсдэл, боломжийг үнэлэх шаардлагатайг тайлбарлав.

Ч.Сономдагва: Техникчийн ажлын байрны тодорхойлолттой холбоотой асуудлыг дурдан, ажлын байрны тодорхойлолтыг сургууль дангаар боловсруулах боломжгүй, хүний нөөцийн асуудал хариуцсан нэгжтэй хамтран шийдвэрлэх шаардлагатайг илэрхийлэв.

Б.Ганбат: Ажлын байрны тодорхойлолтыг боловсруулах, шинэчлэх асуудлыг Захиргаа, хүний нөөцийн газарт уламжлан шийдвэрлүүлэх нь зүйтэйг тайлбарлав.

Б.Очирхуяг: Нэгдсэн менежментийн тогтолцооны хэрэгжилтийг удирдлагын түвшинд шийдвэрлэх шаардлагатай асуудлуудыг тодруулахыг хүсэв. Бүрэлдэхүүн сургууль бүрд ISO хариуцсан баг ажиллуулах, эрсдэлийн үнэлгээг тогтмол хийх, холбогдох арга хэмжээг жилийн ажлын төлөвлөгөөтэй уялдуулах асуудлыг Захирлуудын зөвлөлөөр хэлэлцүүлэх боломжтойг дурдав.

Б.Ганбат: Сургууль бүр үйл ажиллагааны эрсдэлээ урьдчилан тодорхойлж, эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатайг тэмдэглэв.

Б.Очирхуяг: Бүрэлдэхүүн сургуулийн захирлуудын жилийн ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн үүрэг даалгаврыг менежментийн тогтолцооны зорилт, эрсдэлийн удирдлагатай уялдуулах нь зүйтэйг онцлов. Мөн шаардлагатай засвар, хөрөнгө оруулалт болон бусад арга хэмжээний зардлыг 2027 оны төсөв боловсруулах явцад тусгах асуудлыг анхааруулав.

Л.Чинзориг: Менежментийн тогтолцооны баримт бичиг бүрдүүлэх, аудитын бэлтгэл хангах ажлын ачаалал захирлын туслахуудад төвлөрч, бусад ажилтны оролцоо хангалтгүй байгааг тэмдэглэв. Бүрэлдэхүүн сургууль бүрд холбогдох чиг үүргийн ажилтнуудыг оролцуулсан ажлын баг байгуулж, ажил үүргийг тодорхой хуваарилах, шаардлагатай тохиолдолд нэмэгдэл ажлын хөлс, урамшууллын асуудлыг шийдвэрлэх санал гаргав.

Мэдээллийн технологи, электроникийн сургуулийн хамтын ажиллагааны туршлагыг бусад сургуульд хэрэгжүүлэх боломжтойг дурдав.

Б.Очирхуяг: ISO стандартын хэрэгжилт нь зөвхөн аудитад бэлтгэх түр хугацааны ажил бус, байгууллагын үйл ажиллагаанд тогтмол хэрэгжих менежментийн тогтолцоо болохыг онцлов.

Дотоод аудитын тайланг холбогдох сургууль, нэгжийн удирдлагад ойрын хугацаанд хүргүүлж, 2027 оны төсөвт тусгах шаардлагатай болон цаашид хэрэгжүүлэх сайжруулалтын арга хэмжээг тодорхой болгох чиглэл өгөв.

Мөн бүрэлдэхүүн сургууль бүрд эрсдэлийн үнэлгээ хийх, ISO хариуцсан багийн зохион байгуулалт, ажилтнуудын оролцоо, урамшуулал болон хэрэгжилтийн хяналтын асуудлыг Захирлуудын зөвлөлөөр хэлэлцүүлж шийдвэрлэх нь зүйтэйг тэмдэглэв.

Холбогдох саналуудыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга П.Лхамсүрэнгээр дамжуулан нэгтгэж, удирдлагын түвшинд танилцуулахыг чиглэл болгов.

ТАВ. ХУРЛААС ӨГСӨН ЧИГЛЭЛ, ЦААШИД ХЭЛЭЛЦҮҮЛЭХ АСУУДАЛ

Хэлэлцүүлгийн үр дүнд дараах асуудлуудаар ажиллах чиглэл өгч, холбогдох асуудлыг Захирлуудын зөвлөлөөр хэлэлцүүлэхээр тогтов.

5.1. Дотоод аудитын тайланг хүргүүлэх

2026 онд хийгдсэн дотоод аудитын тайланг холбогдох бүрэлдэхүүн сургууль, нэгжийн удирдлагад хүргүүлж, тайланд туссан анхаарах асуудал, сайжруулах боломж, шаардлагатай арга хэмжээний талаар мэдээлэл өгөх.

5.2. Эрсдэлийн удирдлагыг сайжруулах

Бүрэлдэхүүн сургууль, нэгж бүрийн үйл ажиллагааны эрсдэл, боломжийг нэгдсэн аргачлалын дагуу тодорхойлж, үнэлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих зохион байгуулалтын асуудлыг удирдлагын түвшинд хэлэлцүүлэх.

5.3. ISO хариуцсан багийн зохион байгуулалтыг хэлэлцүүлэх

Бүрэлдэхүүн сургууль бүрд нэгдсэн менежментийн тогтолцооны хэрэгжилтийг хариуцах баг ажиллуулах, холбогдох ажилтнуудын үүрэг, хариуцлага, оролцоо болон

урамшууллын зохицуулалтын асуудлыг Захирлуудын зөвлөлөөр хэлэлцүүлж шийдвэрлүүлэх.

5.4. Жилийн ажлын төлөвлөгөөтэй уялдуулах

Нэгдсэн менежментийн тогтолцооны зорилт, эрсдэлийн удирдлага, дотоод аудитын зөвлөмж болон сайжруулалтын арга хэмжээг бүрэлдэхүүн сургууль, нэгжийн жилийн ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн үнэлгээтэй уялдуулах асуудлыг судлан танилцуулах.

5.5. Төсөв, нөөцийн хэрэгцээг тодорхойлох

Дотоод аудитын тайланд туссан сургалтын орчин, хүртээмж, барилга байгууламжийн аюулгүй байдал, засвар, хөрөнгө оруулалт болон бусад нөөц шаардсан асуудлыг холбогдох нэгжүүдээр судлуулж, шаардлагатай арга хэмжээг 2027 оны төсөвт тусгах боломжийг авч үзэх.

5.6. Удирдлагын түвшинд шийдвэрлүүлэх асуудлыг нэгтгэх

Хурлын хэлэлцүүлгийн явцад гарсан санал, дотоод аудитын үр дүн, эрсдэлийн удирдлага, хүний нөөц, хариуцлагын хуваарилалт болон нөөцийн хэрэгцээтэй холбоотой асуудлыг нэгтгэн, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга П.Лхамсүрэнгээр дамжуулан Захирлуудын зөвлөлийн хуралд танилцуулах.

Тайлбар: Энэхүү хурлаар Захирлуудын зөвлөлөөр хэлэлцүүлэхээр чиглэл болгосон асуудлуудыг эцэслэн баталсан шийдвэр гэж үзэхгүй бөгөөд холбогдох шийдвэрийг эрх бүхий удирдлагын түвшинд гаргана.

Хурал 11:00 цагт өндөрлөв.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн: Ж.Дэлгэрмөнх

Хянасан: Б.Ганбат